



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Дээд шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 18 нэрийн, нийт 43,771,082.00 (дөчин гурван сая долоон зуун далан нэгэн мянга наян хоёр) төгрөгийн балансын үнэ, 29,397,196.61 (хорин есөн сая гурван зуун ерэн долоон мянга нэг зуун ерэн зургаан төгрөг жаран нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Монгол Улсын Дээд шүүхийн тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа шүүхийн тамгын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Тогтоолын биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИГЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Хүлээн авах байгууллага
1	Сандал	2024.03.25		6	12,200.00	73,200.00	8,540.00	64,660.00	Баянхонгор аймаг дахь шүүхийн Тамгын газар
2	Ширээ/хурлын/	2024.03.25		1	197,000.00	197,000.00	114,916.62	82,083.38	
3	Индэр /нийслэл/	2022.12.30		1	120,000.00	120,000.00	33,333.31	86,666.69	
4	ширээ	2022.12.30		2	180,000.00	360,000.00	130,000.00	230,000.00	
5	сандал	2022.12.30		9	80,700.00	726,300.00	262,275.39	464,024.61	
6	сандал	2022.12.30		1	80,700.00	80,700.00	29,141.71	51,558.29	
7	Зурагт /75 инч/	2019.12.09		1	6,145,700.00	6,145,700.00	4,884,086.07	1,261,613.93	Өвөрхангай аймаг дахь шүүхийн Тамгын газар
8	Сандал	2024.03.25		1	20,000.00	20,000.00	11,666.62	8,333.38	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар
9	ХТ-ын ИТХ сандал	2025.11.30		30	80,700.00	2,421,000.00	874,249.35	1,546,750.65	Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн Тамгын газар
10	Сандал	2018.10.23		4	1,849,545.50	7,398,182.00	3,666,770.50	3,731,411.50	
11	Ширээ	2024.03.24		1	121,000.00	121,000.00	70,583.38	50,416.62	
12	Тоёота камри 01-42 УНУ	2024.03.25		1	10,000,000.00	10,000,000.00	5,833,333.31	4,166,666.69	Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн академи
13	Хэвлэлийнхний сандал	2009.12.31		54	219,000.00	11,826,000.00	11,826,000.00	-	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар
14	ширээ	2022.12.30		17	180,000.00	3,060,000.00	1,105,000.00	1,955,000.00	
15	ширээ	2022.12.30		1	180,000.00	180,000.00	65,000.00	115,000.00	
16	сандал	2024.11.30		7	80,700.00	564,900.00	203,991.97	360,908.03	
17	Сандал	2024.03.25		8	48,200.00	385,600.00	224,933.38	160,666.62	
18	Ширээ хурлын	2024.03.25		1	91,500.00	91,500.00	53,375.00	38,125.00	
Нийт дүн				146		43,771,082.00	29,397,196.61	14,373,885.39	(арван дөрвөн сая гурван зуун далан гурван мянга найман зуун наян таван төгрөг гучин есөн мөнгө)
						(дөчин гурван сая долоон зуун далан нэгэн мянга наян хоёр төгрөг)	(хорин есөн сая гурван зуун ерэн долоон мянга нэг зуун ерэн зургаан төгрөг жаран нэгэн мөнгө)		